



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Банк бус санхүүгийн байгууллагын хувь  
нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах,  
шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд  
мөрдөх журам” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5 дугаар бүлгийн 5.1 дэх хэсэг, уг журмын 1 дүгээр хавсралтын “СЗХ02002” маягтын 1 дүгээр хэсгийн А, Б, 2 дугаар хавсралтын “В” жагсаалтыг тус тусхүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН  
ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХОРОГДУУЛАХ, ШИНЭЭР ХУВЬЦАА ГАРГАХ,  
ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос банк бус санхүүгийн байгууллага /цаашид “ББСБ” гэх/-ын хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахад тавигдах шаардлагыг тодорхойлоход оршино.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 380 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

**ХОЁР. ТАВИГДАХ ШААРДЛАГА**

2.1. Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн иргэний хувьд татвар төлсний дараах орлого, хуулийн этгээдийн хувьд жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, татварын тайлангаар баталгаажсан хуримтлагдсан ашиг болон хөрөнгө борлуулсны орлого байна.

2.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд дараах байдлаар өөрчлөлт оруулна:

2.2.1. тухайн банк бус санхүүгийн байгууллагын тайлант жилийн ашгаас хувьцаа эзэмшигчид хуваарилсан татвар төлсний дараах ногдол ашгаар нэмэгдүүлэх;

2.2.2. хувьцаа эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн татварын тайлан, татвар төлсний дараах хууль ёсны орлогоор нэмэгдүүлэх;

2.2.3. шинээр хувьцаа гаргах;

2.2.4. хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа бэлэглэх, өвлүүлэх, эсхүл бусад хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдэд худалдах;

2.2.5. хууль болон холбогдох журамд заасан бусад хэлбэрээр нэмэгдүүлэх;

2.2.6. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангах боломжтой, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулснаар бусад хувьцаа эзэмшигч, харилцагчдад хохирол учруулахгүй бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хорогдуулах.

2.3. Банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигч, хувьцааг худалдан авагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог, эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаарын мэдээллийг Хороонд ирүүлнэ.

2.4. Энэ журмын 2.3 дахь эцсийн өмчлөгч өөрчлөгдсөн тохиолдолд өөрчлөлт орсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эцсийн өмчлөгчдийн өөрчлөлтийн мэдээллийг Хороонд ирүүлнэ.

2.5. Энэ журмын 2.2.1, 2.2.2, 2.3, 2.4 дэх заалт нь хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй ББСБ-д хамаарахгүй бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооноос баталсан журмаар зохицуулна.

2.6. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн хүсэлт гаргаж буй ББСБ нь Хорооны дарга шийдвэрлэх хүртэлх хугацаанд хувь нийлүүлэх мөнгөн хөрөнгийг байршуулсан данснаас зарлагын гүйлгээ хийхдээ нэмэгдүүлэх зөвшөөрөл хүссэн хувь нийлүүлсэн хөрөнгийг бууруулсан гүйлгээ хийхийг хориглоно. */Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 380 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

2.7. Хорооны даргад танилцуулж, шийдвэрлүүлэхээс 2 өдрийн өмнө хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг байршуулсан банкны тодорхойлолт, дансны хуулгыг Хороонд ирүүлэх ба холбогдох ажилтан энэ журмын 2.6 дахь заалтын хэрэгжилтийг шалган баталгаажуулсан байна.

2.8. Банк бус санхүүгийн байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хүсэлтээ энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан өргөдлийн маягтын дагуу гаргаж, 2 дугаар хавсралтад заасан баримт бичгийг хавсаргаж Хороонд бичгээр болон цахимаар ирүүлнэ. */Энэ хэсгийн дугаарлалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 380 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

2.9. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д заасны дагуу ББСБ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай бүр Хорооны даргын шийдвэрийг үндэслэн холбогдох гүйлгээг хийнэ. */Энэ хэсгийн дугаарлалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 380 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

2.10. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа ББСБ нь Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэнэ. */Энэ хэсгийн дугаарлалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 380 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

2.11. ББСБ нь өөрчлөлт орсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл эх хувийг Хороонд ирүүлнэ. *Энэ хэсгийн дугаарлалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 380 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан.*

## ГУРАВ. ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

*/Энэ бүлгийн гарчгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 380 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./*

~~3.1. Банк бус санхүүгийн байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хүсэлтээ энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан өргөдлийн маягтын дагуу гаргаж, 2 дугаар хавсралтад заасан баримт бичгийг хавсаргаж Хороонд бичгээр болон цахимаар ирүүлнэ. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 380 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./~~

~~3.2. Зөвшөөрөл авахаар ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг холбогдох ажилтан хянаж, зөвлөгөө огох бөгөөд тухайн өргөдөл, баримт бичгийн бүрдүүлбэр, шаардлагыг хангасан тохиолдолд Хорооны бичиг хэрэгт бүртгүүлнэ. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 380 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./~~

## ДӨРӨВ. ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ

*/Энэ бүлгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 380 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

~~4.1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрлийг дараах үндэслэлээр олгохоос татгалзана:~~

~~4.1.1. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгө нь хууль~~

~~ёсны үйл ажиллагаанаас өлсөн болох нь нотлогдоогүй;~~

~~4.1.2. энэхүү журмын 2.6 дахь заалтыг зөрчиж хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгөөс зарлагын гүйлгээ хийсэн;~~

~~4.1.3. хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, оорчлолт оруулахаар нийдвэрлэсэн эрх бүхий этгээдийн нийдвэр болон гэрээ хэлцэл хуурамч болох нь нотлогдсон.~~

~~4.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзан тохиолдолд хүсэлт гаргагчид Хөрөнги асуудал хариуцсан газрын даргын албан бичгээр мэдэгдэнэ.~~

## ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

“Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ын 1 дүгээр хавсралт

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр		
Өргөдөл/хүсэлт гаргагч ББСБ-ын оноосон нэр							
Регистрийн дугаар							
<b>Хэсэг 1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах</b>							
<input type="checkbox"/> Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах <input type="checkbox"/> Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах							
<b>А. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд шинээр орж буй этгээдийн хувьд:</b>							
Оноосон нэр /Овог, нэр/	Харьяалал	РД	Хувьцааны тоо (ш)	ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)	Хаяг, утас	
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)							
<b>Б. Хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт орсон тохиолдолд:</b>							
Д/д	Оноосон нэр /Овог, нэр/	РД	Одоогийн ХНХ хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсон дараах ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
Хуулийн этгээд							
Иргэн							
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)							
<b>В. Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл</b>							
Хуулийн этгээдийн нэр	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн нэр	Регистрийн дугаар	Хуулийн этгээдийн хувьцааны эзэмшил хувь	Хаяг, холбоо барих утас			
<b>Г. Шинэ хувьцаа эзэмшигч компанийн нэгдлийн мэдээлэл</b>							
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?					1 ийм <input type="checkbox"/>	үгүй <input type="checkbox"/>	
Тийм бол доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү.							
Оноосон нэр							
Компанийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани			<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани			
Тусгай зөвшөөрөл хүсэгч компанитай ямар холбоотой болох				<input type="checkbox"/> Толгой		<input type="checkbox"/> Хараат	
				<input type="checkbox"/> Охин		<input type="checkbox"/> Зэргэлдээ	
Байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр		
Үйл ажиллагааны төрөл							
Хаяг	Аймаг/ хот						
	Сум/дүүрэг						
	Баг/хороо						
	Гудамж, байр						
	Тоот						
Холбоо барих утас							
Цахим хуудас							
Цахим хаяг							

“Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах шинээр хувьцаа гаргах, худалдах,шилжүүлэхэд мөрдөх журам”-ын 2 дугаар хавсралт

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЭЦ, ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ӨРГӨДӨЛД  
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, холбогдох гэрээ хэлцэл, нотлох баримт бичиг	
2	Иргэний хуулийн дагуу өмчлөх эрхээ өвлүүлсэн, бэлэглэсэн тухай хэлцэл, нотлох баримт бичиг	
3	Хувьцаагаа худалдахаар санал болгож байгаа хувьцаа эзэмшигчийн хүргүүлсэн саналыг бусад хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсэн албан бичгийн хуулбар	
4	Шинээр орж буй хувьцаа эзэмшигчийн хувьд хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийн гарал үүслийн талаарх тодорхойлолт, хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж буйг нотлох баримт бичиг	
5	Хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийг дансанд байршуулсан болохыг тодорхойлсон банкны тодорхойлолт, дансны хуулга	
6	ББСБ нь хувь хөрөнгөө хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлж буй тохиолдолд тухайн жилүүдийн аудитлагдсан санхүүгийн тайлан, харьяалах татварын байгууллагаас баталгаажуулсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан	
7	Нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь	
8	Шаардлагатай бусад	